

203-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД 3-РАНГИЙН СУРАГЧДААС АВАХ АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН БЛЮПРИНТ- НЭГДМЭЛ АГУУЛГА


Анги: 3

Хугацаа: 40мин

АТБХ	Суралцахуйн зорилт	Битүү /сонгох хариутай/ даалгавар				Нээлттэй /задгай/ даалгавар				Нийт	Даалгаврын эзлэх хувь
		Ойлгох	Хэрэглэх	Задлан шинжлэх	Бүгд	Ойлгох	Хэрэглэх	Задлан шинжлэх	Бүгд		
Тоо тоолол	3.1д. Арван мянга доторх тоог орны нэмэгдэхүүний нийлбэрт задлах, нэмэх, хасах, аравт зуугад ойр байх хоёр тоог цээжээр нэмэх, хасах, ойролцоогоор тооцоолох.	1/1			1/1					1/1	8.3
	3.1и. Тоо хэмжээний 2,3,4,5,6,8,10-ны хэсгийг олох, нийлбэр нь 1-ээс хэтрэхгүй үед ижил хуваарьтай энгийн бутархайнуудыг нэмэх, хасах		1/1		1/1					1/1	8.3
Хэмжиг дэхүүн	3.2б.Тохирох хэрэгсэл хэмжих нэгжийг \мл,см, дм, м, км, гр, кг, т, ц, мл, л\ сонгон урт, хүнд эзэлхүүнийг, \шингэний хэмжээ савны багтаамж\ хэмжих, хэмжээг жиших, баримжаалах, хэмжих хэрэгслийн хуваарын утгыг тайлбарлах, нэг нэгжийг нөгөө нэгжээр илэрхийлэх, дүрсийн хүрээний уртыг олох.						1/2		1/2	½	8.3
Геометр	3.3в Гэр сургууль орчны зам тоглох газрын байршлыг хэлэх, зураг хүснэг дэх дүрс юмсийн байршлыг бичих, заасан байршилд хүрэх зам чиглэлийг тодорхойлох, шилжүүлэх.	1/1			1/1					1/1	8.3
Өгөгдөлгө и ажиллах	3.4а Юмсыг нэг хоёр шинжээр Карролл, Эйлер-Веннийн диаграмм хэрэглэн ангилал		1/1		1/1					1/1	8.3
	3.4б Ажиглалт, хялбар туршилтаар өгөгдөл, мэдээллийг цуглуулах, хүснэгтэд бүртгэх, зурган, баганан диаграммаар илэрхийлэн асуултад хариуилах							1/3		1/3	1/3
Ушиг	3.1в.Уншсан үлгэр өгүүлэг дэх баатрын үйл хөдлөлийн учир шалгааныг тайлбарлах	1/1			1/1					1/1	8.3
	3.1д. Уншсан зохиолын баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлах	1/1/	1/1		2/2					2/2	16.7
Бичих	3.2д. Баярласан сэтгэлээ илэрхийлж бүтцийн дагуу талархсан утгатай захидал бичих							1/3		1/3	8.3
	3.2л. Уншсан зохиолын талаар сэтгэгдлээ илэрхийлэн бичих						1/2		1/2	½	8.3
Хэл зүй	3.4б Уншсан эхээс анхааруулах өгүүлбэрийг ялган таних, бичихдээ анхаарлын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх		1/1		1/1					1/1	8.3
Нэгтгэл	Даалгаврын тоо /даалгаврын оноо	4/4	4/4		8/8		3/7	1/3	4/10	12/18	100
	Онооны нийт эзлэх хувь	22.2	22.2		44.4		38.9	16.7	55.6	100	66,7

ОНООНЫ ХЭВИЙН ТАРХАЛТ

Танин мэдэхүйн түвшин	Сонгох даалгаврын оноо	Онооны эзлэх хувь	Задгай даалгаврын оноо	Онооны эзлэх хувь	Нийт оноо	Нийт онооны эзлэх хувь
Ойлгох	4	50	0	0	4	22.2
Хэрэглэх	4	50	7	70	11	61.1
Задлан шинжлэх	0	0	3	30	3	16.7
Нийт	8	100	10	100	18	100



ДААЛГАВРЫН ХАРИУ ҮНЭЛЭХ СХЕМ

№	Суралцахуйн зорилт	Хэлбэр	Түвшин	Авах оноо	Хариулт		Онооны тайлбар
					А хувилбар	Б хувилбар	
1	3.1д. Арван мянга доторх тоог орны нэмэгдэхүүний нийлбэрт задлах, нэмэх, хасах, аравт зуугад ойр байх хоёр тоог цээжээр нэмэх, хасах, ойролцоогоор тооцоолох.	Сонгох	Мэдлэг ойлголт	1	В	В	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
2	3.3в Гэр сургууль орчны зам тоглох газрын байршлыг хэлэх, зураг хүснэг дэх дүрс юмсийн байршлыг бичих, заасан байршилд хүрэх зам чиглэлийг тодорхойлох, шилжүүлэх.			1	В	Г	
3	3.1и. Тоо хэмжээний 2,3,4,5,6,8,10-ны хэсгийг олох, нийлбэр нь 1-ээс хэтрэхгүй үед ижил хуваарьтай энгийн бутархайнуудыг нэмэх, хасах		Хэрэглэх	1	Б	Г	
4	3.4а Юмсыг нэг хоёр шинжээр Карролл, Эйлер-Веннийн диаграмм хэрэглэн ангилах			1	Б	Г	
5	3.2б.Тохирох хэрэгсэл хэмжих нэгжийг \мл,см, дм, м, км, гр, кг, т, ц, мл, л\ сонгон урт, хүнд эзэлхүүнийг, \шингэний хэмжээ савны багтаамж\ хэмжих, хэмжээг жиших, баримжаалах, хэмжих хэрэгслийн хуваарын утгыг тайлбарлах, нэг нэгжийг нөгөө нэгжээр илэрхийлэх, дүрсийн хүрэээний уртыг олох.	Задгай	Хэрэглэх	2	А.676 см.кв Б.4, 4	А.104 Б.4,4	Даалгавар тус бүр 1 оноо
6	3.4б Ажиглалт, хялбар туршилтаар өгөгдөл, мэдээллийг цуглуулах, хүснэгтэд бүртгэх, зурган, баганан диаграммаар илэрхийлэн асуултад хариуилах			3	А.15, 15, 10, 20 Б.60 кг В.Хүснэгтэнд зөв байгуулах	А.10, 15, 20, 5 Б.50 кг В.Хүснэгтэнд зөв байгуулах	Даалгавар тус бүр 1 оноо
1	3.1в.Уншсан үлгэр өгүүллэг дэх баатрын үйл хөдлөлийн учир шалгааныг тайлбарлах	Сонгох	Мэдлэг ойлголт	1	Г	А	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо
2	3.1д. Уншсан зохиолын баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлах			1	Г	Г	
3	3.1д. Уншсан зохиолын баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлах		Хэрэглэх	1	А	Б	
4	3.4б Уншсан эхээс анхааруулах өгүүллэрийг ялган таних, бичихдээ анхаарлын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх			1	В	В	
5	3.2л. Уншсан зохиолын талаар сэтгэгдлээ илэрхийлэн бичих	Задгай	Мэдлэг ойлгол	2	Нохойг хөөх тухай, муурыг хамгаалах тухай		Зөв үйл хийх тухай гаргасан бол 2 оноо, санаа дутмаг бол 1 оноо
6	3.2д. Баярласан сэтгэлээ илэрхийлж бүтцийн дагуу талархсан утгатай захидал бичих		Задлан шинжлэх	3	Захидлын бүтэц зөв гаргах Хэн нэгэнд баярласан сэтгэгдлээ оновчтой, найруулгатай гаргасан байх, алдаагүй зөв бичсэн байх		-Захидлын бүтэц 1 оноо -Утга санаа зөв гарсан бол 1 оноо -Үгийн алдаа 0-3 алдвал 1 оноо 4-8 алсан бол 0,5 оноо 9 дээш бол 1 оноо

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Б.ЭНХЖАРГАЛ

АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

..... ангийн сурагч

А. ХУВИЛБАР

МАТЕМАТИК

Сонгох даалгавар: Зөвхөн зөв гэсэн нэг хариултаа сонгоно.

1. Нүдэнд ямар тэмдэг тавих вэ?

$300+250$ 550





А. <

Б. >


В. =

Г. Аль нь биш

2. Дүрсийг дээш нь 2 нүд шилжүүлэн зурсан зургийг олоорой.



3. Бат хашааныхаа $\frac{3}{6}$ хэсгийг өглөө $\frac{2}{6}$ хэсгийн орой будсан бол Батын нийт хашаагаа будсан хэсгийн дүрс аль нь вэ?



4. Дараах дүрсүүдийг шинжээр нь хүснэгтэд зөв байрлуулсан хэсэг аль нь вэ? Сонгоорой.

А.

	Олон өнцөгт	4 өнцөгт
Тэгш хэмтэй		
Тэгш хэмгүй		

Б.

	Олон өнцөгт	4 өнцөгт
Тэгш хэмтэй		
Тэгш хэмгүй		

В.

	Олон өнцөгт	4 өнцөгт
Тэгш хэмтэй		
Тэгш хэмгүй		

Г.

	Олон өнцөгт	4 өнцөгт
Тэгш хэмтэй		
Тэгш хэмгүй		


ЗАДГАЙ ДААЛГАВАР





5. Квадратын нэг тал нь 26 см бол дараах даалгавруудыг гүйцэтгээрэй. \2 оноо\

А.Квадратын талбайг олоорой.


Б.Цэгийн оронд тохирох тоог нөхөж бичээрэй.

Квадрат нь тал,оройтой.

6. Дараах даалгаврыг гүйцэтгээрэй. Түлхүүр  5 кг \3 оноо\

Лууван	
Төмс	
Өргөст хэмх	
Улаан лооль	

А. Хураасан ногоо тус бүрийг олоорой.



Б. Нийт хэдэн кг ногоо болсон бэ?

В Хүнсний ногоо тус бүрийн нийт кг-аар баганан диаграмд байрлуулаарай



МОНГОЛ ХЭЛ

Эхийг зөв, хурдан, ойлгож уншаарай

Муу даа

Айсандаа үсээ өрвийлгөж, хашааны ёроол руу шигдсэн муурын бяцхан зулзагыг нохой ууртайгаар боргоож байлаа. Муурын зулзага амаа ангайлган байдаг чадлаараа орилох ажээ. Хажууханд нь хоёр хүүхэд тэдний яахыг сонирхон хүлээнэ. Гэтэл цонхоор нэгэн бүсгүй тэднийг харангуут довжоон дээрээ яаран гарч ирээд, нохойг хөөлөө. Тэгснээ хүүхдүүд рүү хандан:

-Та нар яагаад хараад зогсоод байгаа юм бэ? Санаа зовохгүй байна уу? гэж ууртай гэгч нь хашхирав.

-Юунд санаа зовох гэж! Бид яагаа ч үгүй шүү дээ! Тэднийг гайхахад:

-Яагаа ч үгүй байдаг чинь л харин муу даа гэж бүсгүй ууртай хэлжээ.

Сонгох даалгавар: Зөвхөн зөв гэсэн нэг хариултаа сонгоно.

1. Хоёр хүү яагаад загнуулсан бэ?

- А. Нохойг зодсон учир
- В. Муурыг зодсон учир

- Б. Нохойг хамгаалаагүй учир
- Г. Муурыг хамгаалаагүй учир

2. Үсээ өрвийлгэж, хашааны ёроолд шигдэх нь ямар дүр төрх гаргасан гэж бодож байна вэ?

- А. Баярласан
- В. Уурласан

- Б. Гайхсан
- Г. Айсан

3. Бүсгүй 2 хүүд “Яагаа ч үгүй байдаг чинь л харин муу даа” гэж хэлсний учир юу вэ?

- А. Хоёр хүүгийн амиа бодсон занг зэмлэсэн
- Б. Муурыг хамгаалсан
- В. Нохойд туслахыг хүссэн
- Г. Амьтдыг гэрээсээ холдуулахыг хүссэн

4. “Юунд санаа зовох гэж! Бид яагаа ч үгүй шүү дээ!” гэсэн өгүүлбэр ямар өгүүлбэр вэ?

- А. Асуух өгүүлбэр
- В. Анхааруулах өгүүлбэр

- Б. Хүүрнэх өгүүлбэр
- Г. Захирах өгүүлбэр

АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

..... ангийн сурагч

Б. ХУВИЛБАР

МАТЕМАТИК

Сонгох даалгавар: Зөвхөн зөв гэсэн нэг хариултаа сонгоно.

1. Дөрвөлжин нүдэнд ямар тэмдэг тавих вэ?

$300+250$

550





А. <

Б. >



В. =

Г. Аль нь биш

2. Дүрсийг доошоо 3 нүд шилжүүлэн зурсан зургийг олоорой.



3. Бат хашааныхаа $\frac{2}{6}$ хэсгийг өглөө $\frac{1}{6}$ хэсгийн орой будсан бол Батын нийт хашаагаа будсан хэсгийн дүрс аль нь вэ?



4. Дараах дүрсүүдийг шинжээр нь хүснэгтэд зөв байрлуулсан хэсэг аль нь вэ? Сонгоорой.

А.

	Олон өнцөгт	4 өнцөгт
Тэгш хэмтэй		
Тэгш хэмгүй		

Б.

	Олон өнцөгт	4 өнцөгт
Тэгш хэмтэй		
Тэгш хэмгүй		

В.

	Олон өнцөгт	4 өнцөгт
Тэгш хэмтэй		
Тэгш хэмгүй		

Г.

	Олон өнцөгт	4 өнцөгт
Тэгш хэмтэй		
Тэгш хэмгүй		

ЗАДГАЙ ДААЛГАВАР





5. Квадратын нэг тал нь 26 см бол дараах даалгавруудыг гүйцэтгээрэй. \2 оноо\

А.Квадратын хүрээний уртыг олоорой.


Б.Цэгийн оронд тохирох тоог нөхөж бичээрэй.

Квадрат нь тал,оройтой.

6. Дараах даалгаврыг гүйцэтгээрэй. Түлхүүр 5 кг \3 оноо\

Лууван	
Төмс	
Өргөст хэмх	
Улаан лооль	

А. Хураасан ногоо тус бүрийг олоорой.



Б. Нийт хэдэн кг ногоо болсон бэ?

В Хүнсний ногоо тус бүрийн нийт кг-аар баганан диаграмд байрлуулаарай



МОНГОЛ ХЭЛ

Эхийг зөв, хурдан, ойлгож уншаарай

Муу даа

Айсандаа үсээ өрвийлгөж, хашааны ёроол руу шигдсэн муурын бяцхан зулзагыг нохой ууртайгаар боргоож байлаа. Муурын зулзага амаа ангайлган байдаг чадлаараа орилох ажээ. Хажууханд нь хоёр хүүхэд тэдний яахыг сонирхон хүлээнэ. Гэтэл цонхоор нэгэн бүсгүй тэднийг харангуут довжоон дээрээ яаран гарч ирээд, нохойг хөөлөө. Тэгснээ хүүхдүүд рүү хандан:

-Та нар яагаад хараад зогсоод байгаа юм бэ? Санаа зовохгүй байна уу? гэж ууртай гэгч нь хашхирав.

-Юунд санаа зовох гэж! Бид яагаа ч үгүй шүү дээ! Тэднийг гайхахад:

-Яагаа ч үгүй байдаг чинь л харин муу даа гэж бүсгүй ууртай хэлжээ.

Сонгох даалгавар: Зөвхөн зөв гэсэн нэг хариултаа сонгоно.

1 . Хоёр хүүхэд яагаад загнуулсан бэ?

- A. Муурыг хамгаалаагүй учир
- B. Муурыг зодсон учир

- B. Нохойг хамгаалаагүй учир
- Г. Нохойг зодсон учир

2. Муур үсээ өрвийлгэж, хашааны ёроолд шигдэх нь ямар дүр төрх гаргасан гэж бодож байна вэ?

- A. Баярласан
- B. Уурласан

- B. Гайхсан
- Г. Айсан

3. Бүсгүй хоёр хүүд “Яагаа ч үгүй байдаг чинь л харин муу даа” гэж хэлсний учир юу вэ?

- A. Амьтдыг гэрээсээ холдуулахыг хүссэн
- B. Хоёр хүүгийн амиа бодсон занг зэмлэсэн
- B. Муурыг хамгаалсан
- Г. Нохойд туслахыг хүссэн

4. “Та нар яагаад хараад зогсоод байгаа юм бэ? Санаа зовохгүй байна уу? ” гэсэн өгүүлбэр ямар өгүүлбэр вэ?

- A. Захирах өгүүлбэр
- B. Асуух өгүүлбэр

- B. Хүүрнэх өгүүлбэр
- Г. Анхааруулах өгүүлбэр

